



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 3 сарын 22 өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Г

Г

Стандарт батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Санхүүгийн хяналт шалгалтын стандартыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж ажиллахыг санхүүгийн хяналт шалгалтын улсын болон ахлах байцаагч нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар /Б.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.БОЛОР

080263



САНГИЙН САЙДЫН 2016 ОНЫ  
107 ДУГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТ

## САНГИЙН ЯАМ

### САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН СТАНДАРТ

---

## АГУУЛГА

- |   |  |       |
|---|--|-------|
| 1. МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР АРГА БАРИЛ-             |  |       |
| Санхүүгийн хяналт шалгалтыг мэргэжлийн өндөр    |  | 3-5   |
| мэдлэг ур чадварын дагуу явуулна.               |  |       |
| 2. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ -Ажлын цар хүрээ гэдэг нь    |  |       |
| санхүүгийн хяналт шалгалтын үед ямар ажил       |  |       |
| гүйцэтгэсэн байх ёстойг харуулсан ухагдахуун.   |  | 5-8   |
| Хяналт шалгалтын үед ажлын цар хүрээг тогтоох   |  |       |
| стандартуудыг энэ хэсэгт харуулсан.             |  |       |
| 3. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ-       |  |       |
| Санхүүгийн хяналт шалгалтыг явуулахдаа хяналт   |  |       |
| шалгалтыг төлөвлөх, мэдээллийг үнэлж дүгнэх,    |  | 8-18  |
| шалгалтын үр дүнг танилцуулах, шалгалтын        |  |       |
| мөрөөр ажиллах гэсэн зарчмыг баримтлана         |  |       |
| 4. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЧАНАРЫН               |  |       |
| СТАНДАРТУУД-Хяналт шалгалтын үйл                |  |       |
| ажиллагааны чанар үр нөлөөг дээшлүүлэх,         |  | 18-19 |
| шалгуулагч байгууллага, харилцагч наарт үзүүлэх |  |       |
| үйлчилгээг чанартай, улам бүр хүртээмжтэй       |  |       |
| болгоход шалгалтын утга, ач холбогдол оршино.   |  |       |
| 5. ХАРААТ БУС БАЙХ-Санхүүгийн шалгалт явуулж    |  |       |
| байгаа улсын байцаагч шалгаж байгаа газрынхаа   |  | 20-21 |
| үйл ажиллагаанаас болон бусад талаар хараат бус |  |       |
| байна.  |  |       |
| 6. ЁС ЗҮЙН СТАНДАРТУУД-Мэргэжлийн ёс зүйтэй     |  |       |
| холбоотой асуудлууд болон олон улсад            |  |       |
| зөвшөөрөгдсөн хяналт шалгалтын байцаагчдын ёс   |  | 21-23 |
| зүйн өрөнхий стандартууд энэ хэсэгт багтана     |  |       |

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

Санхүүгийн хяналт, шалгалтанд төрийн захиргааны болон Засгийн газраас байгуулдаг бусад байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдана.

Төрийн санхүүгийн үйл ажиллагаа нь татвар төлөгчдөөс төвлөрүүлсэн төсвийн хөрөнгийг тухайн улс орны нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө хууль тогтоомжийн хүрээнд зарцуулах зорилготой. Төрийн бүх тогтолцоонд байдаг энэхүү зорилгоос “Бусдын мөнгийг захиран зарцуулахад зайлшгүй хяналт шаардлагатай” гэсэн зарчим үндэслэн гарсан.

Хяналт шалгалт нь өөрөө эцсийн зорилго биш. Харин хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээнээс гажих, төсвийн зарцуулалт ба аж ахуйн хөтлөлт нь хуулийн дагуу, аж ахуйч, хэмнэлттэй байдлаар, зориулалтын дагуу явагдаж буй эсэхийг үндсэн баримтад тулгуурлан шалгаж зөрчлийг тухай бүр нь илрүүлдэг, түүнийг дахин гаргахгүй байх талаар зөвлөн тусладаг үйл ажиллагаа юм.

Санхүүгийн хяналт шалгалт хийгдсэнээр төсвийн ерөнхийлөн захирагчид:

- Төсөв хэмнэлттэй, зүй зохистой зарцуулагдаж буй эсэхэд дүгнэлт өгөх
- Хариуцлагын тогтолцоог сайжруулах
- Учирсан хохирлыг нөхөн төлүүлэх
- Зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх
- Үүсч болох эрсдэлийг бууруулах зэрэг бодитой, үр дүнтэй арга хэмжээ авах боломжтой болно.

### Санхүүгийн хяналт шалгалтын чиглэл

1. Санхүү, төсвийн холбогдолтой хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт
2. Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт
3. Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт
4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт
5. Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал
6. Төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт зарцуулалт, үр дүн
7. Гадаад улс орон, олон улсын байгууллага, Засгийн газрын зээл, тусламж, эргэн төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, үр дүн

8. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдийн ашиглалт, үр дүн
9. Байгууллагын няглан бодогчийн хууль тогтоомжид заасан үргийн биелэлт

## 1. МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР АРГА БАРИЛ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ МЭРГЭЖЛИЙН ӨНДӨР ЧАДВАРЫН ДАГУУ ЯВУУЛНА.

Санхүүгийн хяналт шалгалтыг мэргэжлийн ур чадварын дагуу явуулах нь байцаагч нэг бүрийн болон санхүүгийн хяналт шалгалтыг явуулж буй байгууллагын даргын хариуцлага байх ёстой.

### *Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага*

1.1 **Ажиллагсад-санхүүгийн хяналт шалгалтын байгууллагын дарга** улсын байцаагчдын боловсролын түвшин болон техник арга ажиллагаа нь санхүүгийн хяналт шалгалт явуулахад тохирох эсэхийг нягтлана.

- 1.1.1 Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагын дарга хяналт шалгалтын ажлыг мэргэжлийн ур чадварын дагуу явуулахад шаардагдах мэргэжил, дадлагын хэмжүүр тогтоон түүний дагуу ажиллагсадаа сонгоно.
- 1.1.2 Улсын байцаагч бүрийн боловсрол, ур чадвар хяналт шалгалтын ажилд тохирсон гэдгийг нягталсан байна.

1.2 **Мэдлэг, дадлага, ур чадвар-** Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчид нь санхүүгийн хяналт шалгалт явуулах үүрэг зорилго, хариуцлагаа хангахуйц мэдлэг, ур чадвар, дадлага бүхий байна.

- 1.2.1 Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагын улсын байцаагч нар мэдлэг чадвар туршлагатай байж байгууллагын үүрэг зорилтгыг хэрэгжүүлнэ. Мөн түүнчлэн шалгалт явуулах арга техник, аргачлал, стандарт зэргийг хяналт шалгалтын ажилд хэрэглэж дадсан байх шаардлагатай.
- 1.2.2 Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага нь шаардлагатай бол няглан бодох бүртгэл, эдийн засаг, статистик, татвар, хууль, мэдээллийн технологи болон бусад нарийн мэргэжлийн зөвлөгөөг гаднаас авна.

1.3 **Удирдах, хянах-**Санхүүгийн шалгалтын байгууллагын дарга санхүүгийн шалгалтын явцыг удирдаж хяналт тавина.

- 1.3.1 Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагын дарга шалгалтын явцад хяналт тавих бөгөөд энэ нь шалгалтын эхнээс аваад дуустал үргэлжилэх ёстой.
- 1.3.2 Санхүүгийн шалгалтыг удирдах, хянах үйл ажиллагаанд дараах зүйл багтана.

- Тухайн шалгалтанд томилогдсон улсын байцаагчийн мэдлэг, дадлага, туршлага шаардлага хангаж буй эсэх
- Шалгалтыг төлөвлөх явцад нь зөвлөгөө өгөх, шалгалтын удирдамжийг батлах
- Шалгалтын зорилго, чиг үүрэг зөв тавигдсан эсэх
- Хяналт шалгалтаар гарсан дүгнэлт, зөрчил дутагдал холбогдох баримтаар баталгаажсан эсэх
- Акт, албан шаардлага, танилцуулга стандартын дагуу болсон эсэх
- Улсын байцаагчид мэдлэг дадлага, туршлага суулгах

1.3.3 Санхүүгийн шалгалтыг удирдах, хянах ажиллагаа нь шалгалтыг явуулж байгаа улсын байцаагчдын мэдлэг, дадлага, туршлага зэргээс хамаарна.

#### *Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч:*

1.4 Стандартын дагуу хяналт шалгалт хийх-Улсын байцаагч санхүүгийн хяналт шалгалтыг мэргэжлийн стандартын дагуу явуулна.

1.4.1 Улсын байцаагч шалгалтыг улсын байцаагчийн “Ёс зүйн стандарт”-ыг баримтлан явуулна

1.5 Мэдлэг, дадлага, ур чадвар –Санхүүгийн хяналт шалгалт хийхэд шаардлагатай мэдлэг дадлага, ур чадварыг улсын байцаагч эзэмшсэн байна.

1.5.1 Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нэг бүр тодорхой мэдлэг чадвар эзэмшсэн байх ёстой.

Үүнд:

- Хяналт шалгалт явуулах арга аргачлал, журам, стандартыг хэрэглэх чадвар. Ямар нэг тохиолдолд гарч болох нөхцөлд нэмэлт техникийн тусламж судалгаагүйгээр өөрийн мэдлэг дадлагаа хэрэглэх чадвар үүнд орно.
- Санхүүгийн тайлан, баримт бичигтэй ажилладаг улсын байцаагч нар нягтлан бodoх бүртгэлийн мэргэжил эзэмшсэн байна.
- Удирдлагын шинжлэх ухааны талаар ойлгоцтой байх
- Нягтлан бodoх бүртгэл, эдийн засаг, татвар, санхүү, тооцооны аргууд, компьютержсэн мэдээллийн системийн талаар мэдлэгтэй байх
- Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудын талаар мэдлэгтэй байх

1.6 Харилцах соёл-улсын байцаагч хүмүүстэй харилцах дадлага эзэмшсэн байна.

- 1.6.1 Хяналт шалгалтын байцаагч нь хүмүүс хоорондын харилцааны чухлыг гүн гүнзгий ойлгож чаддаг, мөн бусад хяналт шалгалтын байцаагч нартай хүндэтгэлтэй зөв боловсон харилцаж чаддаг байх ёстой.
- 1.6.2 Хяналт шалгалтын байцаагч нар бичгийн болон ярианы дадлага эзэмшсэн байх ёстой бөгөөд энэ дадлага туршлага нь шалгалтын зорилго, үр дүн, илрүүлсэн зөрчил, зөвлөмж зэргээ бусдад ойлгомжтой зөв таниулахад чухал байна.

1.7 **Боловсролоо дээшлүүлэх**-Улсын байцаагч нь цаг үетэй уялдуулан өөрсдийн техник арга ажиллагаа, мэдлэг боловсролоо дээшлүүлнэ.

- 1.7.1 Шинээр гарч буй хяналт шалгалтын арга техник, аргачилал, стандарт бүрийг цаг тухайд нь мэдэж судалж байх шаардлагатай. Боловсролоо мэргэжлийн холбоодод гишүүнээр элсэх, хурал, зөвлөгөөн, семинарт оролцох, их сургуулиудын курст суралцах, бие даан гэрээр суралцах, судалгааны төсөлд оролцох зэргээр дээшлүүлэх ёстой.

## 2. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ ГЭДЭГ НЬ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЕД ЯМАР АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙХ ЁСТОЙГ ХАРУУЛСАН УХАГДАХУУН. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЕД АЖЛЫН ЦАР ХҮРЭЭГ ТОГТООХ СТАНДАРТУУДЫГ ЭНЭ ХЭСЭГТ ХАРУУЛСАН.

Санхүүгийн хяналт шалгалтын удирдлага шалгалтын ерөнхий цар хүрээ болон үйл ажиллагааг зааж тодорхойлж өгсөн байна.

### 2.1 Шалгагдаж байгаа байгууллагын дотоод хяналтын системийг үнэлж дүгнэх

- 2.1.1 Байгууллагын дотоод хяналтыг үнэлж дүгнэх нь уг байгууллагын үйл ажиллагаа өөрийн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдийн засгийн хувьд оновчтой, үр ашигтай байдалд ажиллаж буй эсэхийг тогтооход чухал ач холбогдолтой юм.
- 2.1.2 Байгууллагын дотоод хяналт шалгалт гэдэг нь байгууллагын удирдлагаас зорилт, үүрэг хариуцлагаа идэвхжүүлэх талаар авсан ямар нэг арга хэмжээ байдаг. Дотоод хяналт нь зөв төлөвлөлт, сайн зохион байгуулалт, оновчтой удирдлагын үр дүнд үр ашгаа өгдөг.
- 2.1.3 Хяналт шалгалт нь урьдчилан сэргийлэх (гарч болох эрсдлээс сэргийлэх), илрүүлэх (хүсэж хүлээгдээгүй тохиолдлыг илрүүлж

засах), чиглүүлэх (ямар нэг ашигтай үйл явдлын суурь эхлэл болох) хэлбэрээр байна.

2.1.4 Хяналт шалгалтын байцаагч шалгаж байгаа байгууллагын төлөвлөлт, зохион байгуулалт, удирдан чиглүүлэх процесийг үнэлж дүгнэж, байгууллагын үүрэг зорилтоо хэрэгжүүлэхэд хэр зохицсон эсэхийг тооцно.

**2.2 Хяналтын ажлын цар хүрээг тогтоохдоо доорх зүйлд анхаарч ажиллана.** Үүнд:

- Баримт мэдээллийн үнэн бодит байдал
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал
- Эд хөрөнгө, нөөц бололцоог үр өгөөж, үр дүнтэйгээр ашигласан эсэх

**2.3 Баримт мэдээллийн үнэн бодит байдал-** Улсын байцаагч шалгагдаж байгаа байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, мэдээллийн эх үүсвэр, мэдээллийг боловсруулж байгаа үйл ажиллагааны үнэн бодит байдал, найдвартай байдлыг нягтлан шалгана.

- Байгууллагын удирдлагад шийдвэр гаргахад зориулагдсан мэдээлэл гаргах үйл явц, мөн түүнчлэн гадны байгууллагын шаардлагаар гаргаж буй мэдээлэл гаргах үйл явц зэргийг хянаж үзнэ.
- Санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн байдал, баримтын агуулга зэргийг нягтлана.
- Бүртгэл тооцооны ажилд тавигдаж байгаа хяналтын байдал

**2.4 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал-**Улсын байцаагч шалгаж байгаа байгууллагын үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж буй эсэхийг шалгаж дүгнэлт өгнө.

2.4.1 Санхүүгийн хяналт шалгалт нь санхүү, төсөв, эдийн засгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хуулийн холбогдох зүйл ангиар авч үзэж дүгнэлт гаргана.

2.4.2 шалгагдаж байгаа аж аүйн нэгж байгууллагатай холбогдолтой төрийн захиргааны эрх бүхий байгууллагын тушаал, захирамж, зааврын биелэлтийг шалгаж цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулна.

2.4.3 шалгагдаж буй байгууллагын хөдөлмөрийн хамтын гэрээ, дотоод журам болон гадаад дотоодын байгууллага, хүмүүстэй байгуулсан

гэрээ, хэлцэл нь санхүү, хууль, эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэхийг хянан үзэж санал зөвлөмж гаргана.

## 2.5 Эд хөрөнгө, нөөц бололцоог үр өгөөж, үр дүнтэйгээр ашигласан эсэх

### 2.5.1 Шалгагдаж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн тайлан, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд тулгуурлан санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

- Тухайн байгууллагад зарлагын падаан, орлогын бүртгэл, эд хөрөнгийн тооллогоос эхлээд хөтлөгдвэл зохих анхан шатны баримтыг бүрэн гүйцэт хөтөлсөн эсэх, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн чанар, тайлан балансын гаргалт тушаалтын байдал
- Мөнгөн хөрөнгө, бараа материалын баримтын бүрдүүлэлт, өр, авлага, тэдгээрийн үлдэгдлийг үндсэн баримтаар баталгаажуулсан эсэх
- Дансны бичилгийг анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлтэй тулган шалгах
- Тухайн байгууллагын эдийн засаг, санхүү, төсвийн гүйцэтгэл, тэдгээрт нөлөөлсөн зүйлийг судалж дүгнэлт өгөх

### 2.5.2 Санхүүгийн хяналт шалгалтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь төсвийн орлого, зарлагын үйл ажиллагаа юм. Төсвийн орлого, зарлагын талаарх холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудад тулгуурлан шалгаж дараах асуудлуудад анхаарч үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

- Тухайн байгууллагын орлогын төлөвлөгөө, түүний биелэлт.
- Төсвөөс санхүүждэг байгууллагад төсвийн зарцуулалтыг зардлын зүйл тус бүрээр судлан шалгаж, тэдгээрийн зарцуулалтыг хууль, тогтоомжийн холбогдох заалттай нь нийцүүлэн авч үзнэ.
- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан эсэхэд онцгойлон анхаарч, үр ашиг багатай зүйлд хөрөнгө мөнгө зарцуулсан байдлыг баримт тооцоогоор баталж цаашид авах арга хэмжээг боловсруулна

### 2.5.3 Төрийн өмч, төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтыг шалгаж, дүгнэлт өгнө. Үүнд:

- Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд нь хийж тооцоог бодож, үр дүнг шийдвэрлэсэн эсэхийг тооллогын бүртгэл, тооцоо бодсон акттай тулгах
- Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт, илүүдэл болон ашиглалтгүй, их хэмжээгээр нөөцлөгдсөн хөрөнгө байгаа эсэх,

- тэдгээрийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх арга замыг тодорхойлох
- Өр авлагын байдал, өссөн буурсан шалтгааныг тодруулж барагдуулахад нь туслах, найдваргүй авлага, эзэнгүй өглөгийг хаасан эсэхэд анхаарах
  - Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдсөн эсэх

**2.5.4 Шалгагдаж буй байгууллага гадаад, дотоодын төсөл хэрэгжүүлж, зээл тусламж болон эргэж төлөгдөх нөхцлөөр зээл авсан бол тэдгээрийг зориуд авч үзэн шалгаж дүгнэлт гаргана. Үүнд:**

- Гэрээний эрх зүйн үндэспэлийг авч үзэж, түүний заалтын хэрэгжилтийг шалгаж дүгнэлт гаргах
- Зээл тусламжийн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан байдал
- Зээлийн хөрөнгө, түүний хүү тухайн байгууллагын бүртгэл, тайлан тэнцэлд тусгагдсан эсэх

### **3.САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ**

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЯВУУЛАХДАА ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, МЭДЭЭЛЛИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ, ШАЛГАЛТЫН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ, ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ СТАНДАРТ, ЗАРЧМЫГ БАРИМТЛАНА.**

#### **3.1 Шалгалтыг төлөвлөх**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч шалгалтын төлөвлөгөөг урьдчилан төлөвлөн боловсруулж, баримтжуулж доорх зүйлсийг багтаасан байна.

##### **3.1.1 Шалгалтын зорилго болон цар хүрээг тодорхойлно.**

- Шалгалтын зорилго гэдэг нь хүлээгдэж байгаа шалгалтыг тодорхойлоход чиглэгдсэн улсын байцаагчийн бэлтгэж боловсруулсан баримт. Шалгалтын аргачлал нь шалгалтын зорилтыг хэрэгжүүлэх арга зам юм. Шалгалтын зорилго болон аргачлалыг цугт нь авч шалгалтын цар хүрээг тодорхойлно.

##### **3.1.2 Шалгагдаж байгаа байгууллагын талаар үндсэн мэдээлэл олж авсан байна.**

Хяналт шалгалтын ажилд нөлөө үзүүлэх тухайн байгууллагын талаарх мэдээ материалыг судлах. Энэ мэдээлэлд:

- Байгууллагын үүрэг хариуцлага, зорилго
- Тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль тогтоомж, эрхийн акт, баримт бичгүүд
- Байгууллагын бүтэц, ажилчдын тоо, гол чухал албан тушаалтнууд, тэдгээрийн нэрс, ажил үүргийн тодорхойлолт, сүүлийн үеийн бүтцийн мэдээлэл
- Төсвийн талаарх мэдээлэл
- Өмнө хийгдсэн хяналт шалгалтын мэдээлэл
- Явуулсан болон ирсэн бичгийн архив

3.1.3 Хяналт шалгалт явуулах хугацааг тогтоосон байна. Энэ хугацааг тогтоохдоо шалгалтын тайлан гаргах хугацааг тооцно.

- Томоохон төрийн өмчийн байгууллага-ажлын 30 хоног
- Томоохон төсөвт байгууллага (жилд 5,000.0 саяас дээш төгрөгийн санхүүжилт авдаг)-ажлын 30 хоног
- Дундаж буюу жилд 1,000.0-5,000.0 сая төгрөгийн санхүүжилт авдаг бол ажлын 20 хоног
- Жижиг, дунд хэмжээний үйлдвэрийн газар 1,000.0-5,000.0 сая төгрөгийн орлого зарлагатай –ажлын 25 хоног
- Бага хэмжээний 1,000.0 саяас бага төгрөгийн санхүүжилт авдаг орлого зарлагатай аж ахуйн нэгж байгууллага, төсөвт газарт бол ажлын 14 хоног
- Хяналт шалгалт явуулах хугацааг тогтоохдоо тухайн байгууллагын цар хүрээ, обьём, баримт материалын байдлыг харгалзан хичнээн байцаагч ажиллуулахыг байгууллагын дарга тогтооно.

3.1.4 Хяналт шалгалт явуулахад шаардлагатай нөхцлүүдийг тодорхойлох

- Шалгалтын зорилго, агуулга, төлөв байдал, цаг хугацааны харгалзал, бэлэн буй материал зэргийг үндэслэн шалгалтанд оролцох улсын байцаагчдын дадлага туршлагыг харгалзан тоог гаргана.
- Шалгалтын онцлогийг харгалзан шалгалт явуулах байцаагчийн мэдлэг, дадлага туршлага, зарчимч байдал зэргийг нь харгалзана.

3.1.5 Шалгалтанд нэмэлт мэдлэг, туршлага шаардлагатай тохиолдолд гадны эх үүсвэрээс олж авна.

3.1.6 Санхүүгийн шалгалтын талаар мэдэж байх ёстой бүх хүмүүстэй холбогдсон байна. Шалгалтын үйл ажиллагаатай шууд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага явуулах. Энэ уулзалт ярилцлагын сэдэвт:

- Төлөвлөгдсөн шалгалтын зорилго, цар хүрээ
- Шалгалт үргэлжилэх хугацаа
- Улсын байцаагчдын талаар
- Шалгалтын явцад харилцаа холбоотой байх

- Байгууллагын удирдлагын зүгээс тавьсан санал, хүсэлт
  - Шалгалтанд хамрагдах чухал асуудлууд
  - Тайлан гаргах болон шалгалтын мөрөөр ажиллах ерөнхий зарчмууд
- 3.1.7 Уулзалт ярилцлагад хүрсэн үр дүн болон тохирсон зүйлийн талаар холбогдох хүмүүст мэдэгдэнэ.

### 3.2 БАРИМТ МЭДЭЭЛЛИЙГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ

УЛСЫН БАЙЦААГЧ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮНГ ХАРУУЛАХ МЭДЭЭ БАРИМТЫГ ЦУГЛУУЛАХ, ҮНЭЛЖ ДҮГНЭХ, ТҮҮНИЙГЭЭ БАРИМТЖУУЛСАН БАЙНА.

3.2.1 Баримт мэдээллийг үнэлж дүгнэх үйл явц доор дурдсанаар явагдана:

Хяналт шалгалтын зорилго, цар хүрээнд тулгуурлан холбогдох бүх баримт бичгийг цуглуулна.

А. Улсын байцаагч нар баримт мэдээг шалгах, дүгнэхдээ шинжилгээний аргыг ашиглана.

Б. Хяналт шалгалтыг явуулах шинжилгээний арга нь санхүүгийн болон санхүүгийн бус баримт мэдээг судалж харьцуулах арга юм. Энэ шинжилгээний аргад:

- Шалгагдаж байгаа үеийн мэдээллийг одоо үеийн мэдээлэлтэй харьцуулах
- Төсвийн төлөвлөлт болон зарцуулалтыг харьцуулах
- Санхүүгийн мэдээллийг холбогдох санхүүгийн бус мэдээлэлтэй харьцуулан судлах /жишээлбэл: цалингийн санг ажилласдыг дундаж тоотой харьцуулах/
- Баримт мэдээллийг бусад өөр салбарын байгууллагын ижил баримт мэдээтэй харьцуулах гэх мэт

В. Хяналт шалгалтанд шинжилгээний бусад арга тухайлбал харьцаа, хандлага, регрессийн шинжилгээ, цаг үеээр харьцуулах зэрэг аргуудыг хэрэглэнэ.

3.2.2 Баримт мэдээ нь шалгалтын үр дүн, илрүүлсэн зүйл, зөвлөмж зэргийг илэрхийлж баталж чадахуйц бодитой, холбогдолтой, хангалттай байх хэрэгтэй.

- Баримт мэдээ хангалттай байна гэдэг нь ямар нэг хүн уг мэдээг хараад шалгасан улсын байцаагчтай ижил дүгнэлтэд хүрэх баримтыг хэлнэ.
- Шаардлага хангасан бодитой баримт мэдээ гэдэг нь шалгалтын явцад олж авсан хамгийн сайн баримт болох материал

- Шалгалтын зорилгод холбогдолтой баримт мэдээ нь шалгалтын үр дүн, зөвлөмжийг тодотгож харуулахад тус дэм болно.
- 3.2.3 Баримт мэдээг цуглуулах, үнэлж дүгнэх, баримтжуулах үйл явц шалгалтын зорилгод нийцэж байх хэрэгтэй бөгөөд улсын байцаагчдын энэ үйл ажиллагааг хянаж удирдаж байх хэрэгтэй.
- 3.2.4 Улсын байцаагч нь санхүүгийн хяналт шалгалтад хамрагдвал зохих бүхий л баримт материалын тоо хэмжээ, хуудасны дугаарыг нэг бүрчлэн тогтоож, эрх бүхий хүмүүсээр гарын үсэг зуруулан хүлээн авч, эргүүлж албан ёсоор хүлээлгэж өгнө.
- 3.2.5 Шалгалт нь шалгуулж байгаа байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхөөргүй эмх цэгц, зохион байгуулалт сайтай, шуурхай байхын зэрэгцээ тухайн байгууллагын ажилд оршиж байгаа дутагдал зөрчлийг илрүүлэн ажилд нь тус дэмжлэг үзүүлэх, хууль бус үйл ажиллагааг таслан зогсооход чиглэгдэнэ.
- 3.2.6 Улсын байцаагч нь санхүүгийн хяналт шалгалтын удирдамжинд заасан асуудлаар хяналт шалгалтыг үнэн зөв, бүрэн гүйцэт хийх үүрэгтэй.
- 3.2.7 Санхүүгийн хяналт шалгалтын явцад шаардлагатай баримт бичгийг гаргуулан авч шинжлэн судалж танилцах, шалгалтын холбогдолтой асуудлаар амаар буюу тайлбар тодорхойлолт авах, ажлын байр, талбай агуулах, бусад холбогдох газарт нэвтрэн орж, тооллого тооцоо, үзлэг шалгалт, зураг авалт хийх, мэргэжлийн хүмүүсийг шалгалтанд татан оролцуулах буюу тодорхой асуудлаар мэргэжлийн байгууллага, хүмүүсийн дүгнэлт гаргуулан дүн шинжилгээ хийлгэж болно.
- 3.2.8 Санхүүгийн хяналт шалгалт хийсэн улсын байцаагч шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, бусад шаардлагатай баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэж, гарын үсгээ зурсны дараа шалгуулсан этгээдэд танилцуулж гарын үсэг зуруулна. Хэрэв шалгуулсан хүмүүс шалгалтын талаар актанд дурьдагдсан зүйл, улсын байцаагчийн дүгнэлтийг зөвшөөрөөгүй тохиолдолд энэ тухай тайлбарыг өөрөөр нь бичүүлж, гарын үсэг зуруулна. Актанд тухайн байцаагч улсын байцаагчийн тэмдгээ дарж баталгаажуулна.
- 3.2.9 Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан улсын байцаагчийн гаргасан албан шийдвэр үндэсплэлгүй гэж үзвэл гомдлоо шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчдад тавьж болно. Уг гомдлыг хүлээн

авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдоо зохих журмын дагуу шүүхэд гаргана.

### 3.3 ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН НОТОЛГОО

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН НОТОЛГОО, НОТЛОХ БАРИМТ НЬ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ҮР ДҮНГ БАТЛАН ХАРУУЛАХАД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ.

- 01.Хяналт шалгалтын байгууллагын үйл ажиллагааны эцсийн үр дүн нь шалгуулагч байгууллагын үйл ажиллагааг үнэн зөвөөр үнэлж дүгнэх, тэдний үйл ажиллагаанд байгаа сайн талыг сайшаан үнэлэхийн зэрэгцээгээр алдаа дутагдалтай талыг засаж, запруулан цаашид дахин давтан гаргахгүй байх арга замыг тэдэнд зөвлөж өгөхөд оршдог. Хяналт шалгалтаар зөрчил дутагдлыг илрүүлэх, тогтоох ажил нь тэдгээр алдаа дутагдлын цаанаа байгаа ашиг сонирхлыг бас олж тогтоон тийм сонирхлыг тухайн байгууллагын үйл ажиллагаанд дахин бий болох нөхцлийг хаахад чиглэгдэнэ.
- 02.Шалгуулагч байгууллагын алдаа дутагдал бүрийг илрүүлж, олж тогтоосны дараа тэдгээрийн нотлох баримт нотолгоог зохих хууль тогтоомжийн заалт бүрээр гаргаж тогтоох нь чухал бөгөөд энэ нь хөдөлшгүй үнэн, баталгаатай байх шаардлагатай байдаг. Хяналт шалгалтын ажилтан нь тухайн хийж гүйцэтгэж байгаа ажлынхаа үнэн зөв баталгаатай байхад байнга анхааран ажиллах хэрэгтэй бөгөөд хяналт шалгалтын ажлын эцсийн тайлан, дүгнэлт гаргахад шалгалтаар илэрсэн алдаа дутагдал болон бусад зүйлүүдийн нотлох баримт нотолгоо нь хуулийн дагуу үнэн зөв, дүгнэлт шийдвэр гаргахад хангалттай хүрэлцэхүйц байх шаардлагатай.
- 03.Хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх төлөвлөгөө, ажлын гүйцэтгэлийн бодит байдал, баталгаат байдал зэрэг нь шалгуулагч байгууллага болон харилцагч түнш нарт өгөх санал зөвлөгөөний үнэ цэнийг улам нэмэгдүүлж хяналт шалгалтын ажлын эцсийн үр дүнг сайн гаргахад нөлөөлдөг чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Хяналт шалгалтын ажлын явцад гарч байгаа бүх мэдээлэл, нотлох баримтыг нэг бүрчлэн авч үзэхээсээ илүү тухайн мэдээллийг ангилан ялгаж авч үзэх нь чухал юм.
- 04.Хяналт шалгалтын ажлын нотолгоо, батлах баримт нь хууль эрх зүйн талаасаа тухайн үйл ажиллагааны явцад хүчин төгөлдөр хэрэгжиж байсан болон одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулийн хүрээнд байх ёстой юм. Мөн тухайн байгууллагын болон нийгмийн ашиг сонирхлыг зөрчсөн, ноцтой зөрчсөнийг тогтоохын зэрэгцээгээр энэ нь байгууллагын өмнөө тавьсан зорилтоо биелүүлээгүй шалтгааны үндэс болсон уу, угүй юу гэдгийг хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байгаа улсын байцаагч заавал тогтоох

хэрэгтэй юм. Энэ нь хяналт шалгалтаар гарч байгаа алдаа дутагдлыг дахин давтан гаргуулахгүй байх гэсэн хяналт шалгалтын байгууллагын зорилтыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтойн дээр тухайн шалгуулагч байгууллагын үйл ажиллагааны өмнөө тодорхойлсоныг гаргаж өгөх ач холбогдолтой юм.

05.Хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх явцдаа хяналт шалгалтын ажлын нотолгоо, батлах баримтын илрэн гарч байгаа учир шалтгааныг тогтоохын дээр тэдгээр нь өөр бусад зүйлүүдтэй ямар холбоотой болохыг олж тогтоохыг зорих хэрэгтэй юм. Эдгээр үйл ажиллагааг дараах дарааллаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

-Хяналт шалгалтын болон тухайн байгууллагын тухайн цаг үеийн

үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулах

-Олж цуглуулсан мэдээллүүдийг үйл ажиллагааны хамрах цар хүрээ, хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа хугацаагаар нь ангилалт хийнэ. Ангилалт хийх арга зүйн талаар журам боловсруулан ажиллах хэрэгтэй.

-Ангилалт хийсэн мэдээллийг боловсруулах. Энэ үе шатанд хяналт шалгалтын ажлын гол хэсэг нь оршдог. Аливаа мэдээллийг маш тодорхой, нарийвчилсан байдлаар авч үзэхийн өмнө ямар мэдээлэл чухал ач холбогдолтойг тогтоон тэдгээр нь эргээд хяналт шалгалтын ажлын эцсийн үр дүн, нэгдсэн дүгнэлт гаргахад баталгаажуулсан байх шаардлагыг хангах хэрэгтэй юм. Хяналт шалгалтын ажлын явцад олж тогтоосон нотлох баримтууд нь үнэн зөв, хөдлөшгүй байх ёстой.

-Хэрвээ хяналт шалгалтын явцад хангальтай хүрэлцэхүйц нотолгоо, батлах баримт олж чадахгүй бол шалгалтын ажлын тайландаа ямар нэгэн далд зүйл байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй.

### 3.4 ШАЛГАЛТЫН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ, МЭДЭЭЛЭХ

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН 5.9-Д ЗААСНЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ БИЧНЭ.

- 01.Хяналт шалгалтыг дууссаны дараа гарын үсэг бүхий шалгалтын тэмдэглэл, нэгбүрчилсэн акт бичнэ. Шалгалтын явцад явц дундуурх шалгалтын дүнг амаар болон бичгээр танилцуулж болох бөгөөд энэ нь албан ба албан бус хэлбэрээр байж болно.
- 02.Явц дундын шалгалтын дүнгээр анхаарал татсан баримт мэдээллийн талаар санал солилцох, ажлын цар хүрээг өөрчлөх, шалгалтын явц заасан хугацаанаас удааширах байдал гарах зэргийг удирдлагад мэдээлэх арга хэмжээ авна.
- 03.Удирдлагад танилцуулах зорилгоор шалгалтын тэмдэглэл, нэг бүрчилсэн актыг үндэслэн шалгалтын үр дүнгийн талаарх гол мэдээллүүдийг багтаан танилцуулга бичнэ.

04. Шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн актыг эцсийн байдлаар гаргахаас өмнө дүгнэлт болон зөвлөмжийн талаар удирдлагатайгаа ярилцаж зөвлөлдсөн байна.
05. Шалгалтын тэмдэглэл, нэг бүрчилсэн актыг утга агуулгатай, ойлгоцтой, товч тодорхой, хугацаанд нь гаргах ёстой.
06. Шалгалтын тэмдэглэлд шалгалтын зорилго, цар хүрээ, үр дүнг харуулж илтгэсэн байх бөгөөд шаардлагатай хэсэгт улсын байцаагчийн санал дүгнэлтийг агуулсан байна.
07. Шалгалтын зорилго, хамрах хүрээнээс хамаарч шалгалтын тэмдэглэлийн хэлбэр, формат өөр өөр байж болно.
08. Шалгалтын тэмдэглэл нь нэгд, нийтлэг зүйл, хоёрт, төрийн өмчтэй аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, эдийн засгийн үйл ажиллагааны байдал, төсвөөс санхүүждэг байгууллагад төсвийн хөрөнгийн зарцуулалтын байдал, гуравт, санхүү, бүртгэлийн ажил, байгууллагын ололтой сайн тал болон шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын тухай, дөрөвт дүгнэх хэсгээс бүрдэнэ.

-Нийтлэг зүйлд: ямар байгууллагын удирдлагын баталсан удирдамжийн дагуу хэн, хэдий хугацаанд шалгалт хийсэн, хамтарч оролцсон хүмүүс, шалгуулсан байгууллага, санхүүгийн баримтыг баталгаажуулж гарын үсэг зурсан албан тушаалтан, шалгалт хийх болсон үндэслэл, шалгасан асуудлын хүрээ, шалгуулсан байгууллагын чиг үүрэг, удирдлага зохион байгуулалтын бүтэц, өмнөх шалгалтын төлбөр зөрчлийн барагдуулалт, шалгалтын явцад зохион байгуулсан ажил үр дүн.

-Хоёрдугаар хэсэгт: Тухайн аж ахуйн нэгж байгууллагын ажлын онцлог байдлаас хамааруулан санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтад эдийн засгийн бодитой дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгнө. Мөн энэ хэсэгт тухайн байгууллагатай холбогдолтой, зайлшгүй шаардлагатай асуудлыг зориуд авч үзнэ. Тухайлбал гадаад, дотоодын төсөлт хэрэгжүүлсэн, зээл тусламж авсан бол тэдгээрийн ашиглалт, зарцуулалтыг шалгаж дүгнэлт өгсөн байна.

-Гуравдугаар хэсэгт: санхүү, бүртгэлийн ажлын зэрэг талуудыг тэмдэглэж хэлэхийн хамт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тодорхой өзэнтэй баримтаар баталгаажуулж бичнэ. Энэ хэсэгт шалгалтын явц болон шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, зөрчил дутагдал гарсан шалтгааныг нарийвчлан үнэн зөв тогтоосон байна.

Шалгуулагч этгээдийн санал, хүсэлтийг тусгана.

Дүгнэх хэсэгт: Төсвийн тухай хуулинд заасныг үндэслэн шалгасан байгууллагын төсөв, эдийн засгийн үйл ажиллагаа, санхүү бүртгэлийн ажилд өгсөн дүгнэлт, албан тушаалтны үйл ажиллагаанд өгөх үнэлгээ, дутагдал зөрчлийг арилгах болон гэм буруутай хүмүүст хүлээлгэх хариуцлагын талаар авах арга хэмжээний саналыг тусгасан байна. Түүнчлэн шалгалтын дүнтэй холбогдож гарсан

улсын хэмжээнд анхаарч, цаашид зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг дэс дараалуулан бичнэ.

#### 09. Нэгбүрчилсэн акт нь тэмдэглэх болон тогтоох хэсгээс бүрдэнэ.

-Тэмдэглэх хэсэгт ямар байгууллагын, хэдий хугацааны санхүү, аж ахуйн чухам ямар баримт материал шалгасныг дурдана. Тухайн асуудал дээр илэрсэн зөрчил дутагдал, төлбөр хохиролын үүсэж гарсан шалтгаан, мөрдөгдөж байгаа ямар хууль тогтоомжийн ямар заалт хэний буруугаар хэрхэн зөрчигдэж, хэдий хэмжээний хохирол учирсныг товч тодорхой бичнэ. Энэ хэсэгт тэмдэглэсэн зүйлүүд үндсэн баримт тооцогоор шалгагдаж батлагдсан байна.

- Тогтоох хэсэгт хууль тогтоомжийн ямар заалтыг үндэслэн хэдий хэмжээний төлбөрийг ямар албан тушаалтай, хэний хэнд хариуцуулахыг тогтоож, улмаар уг төлбөрийг аль банкны ямар дансанд хэдий хугацаанд төлж барагдуулахыг зааж өгнө.

Актын төгсгөлд акт тогтоосон улсын байцаагчийн албан тушаал, овог нэр, гарын үсэг, тэмдэг, актыг хүлээж авсан байгууллагын эрх бүхий албан тушаалтаны албан тушаал, овог нэр, гарын үсэг, актыг хүлээн зөвшөөрөөгүй бол тайлбар байна.

#### 10. Албан шаардлага

Улсын байцаагчийн албан шаардлага нь, тэмдэглэх, шаардах гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

-Тэмдэглэх хэсэгт, шалгасан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, илэрсэн алдаа, зөрчлийн утга, түүний шалтгааныг товч тодорхой бичнэ.

-Шаардах хэсэгт, илэрсэн алдаа, зөрчлийг таслан зогсоох буюу арилгуулахын тулд эрх бүхий этгээдэд өгч байгаа үүрэг даалгавар, шаардлага, түүнийг биелүүлэх, хариу ирүүлэх хугацаа, хэрэв зөрчлийг арилгаагүй, заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох хууль тогтоомжийг тусгана.

Албан шаардлагын төгсгөлд албан шаардлага бичсэн улсын байцаагчийн албан тушаал, овог нэр, гарын үсэг, тэмдэг, шаардлагыг хүлээн авсан хүний албан тушаал, овог нэр, гарын үсэг байна.

#### 11. Шалгалтын тэмдэглэлд төлбөр зөрчлийн жагсаалт, нэг бүрчилсэн акт, захиргааны шийтгэл ногдуулсан шийтгэвэр, хяналт шалгалтанд оролцсон холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсийн дүгнэлт, бусад холбогдох материалыг хавсаргасан байна.

12. Улсын байцааг нь хяналт шалгалт явуулсан тухай бүрт шалгалтын тэмдэглэл, нэгбүрчилсэн актандaa тулгуурлан танилцуулга бичиж дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр оруулна. Дээрх хурлаар шалгалтын дүнг хэлэлцэн дүгнэж, улсын байцаагчийн тавьсан актыг батална.

13. Санхүүгийн хяналт шалгалтын дүнг хурлаар авч хэлэлцээд өгсөн удирдамж чиглэл, тухайн байгууллагын санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны үнэлэлт, дүгнэлтийг дурьдахын хамт зөрчил дутагдлыг арилгах, цаашид авах арга хэмжээ, учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг асуудлаар хугацаа заасан үүрэг, зөвлөмж бүхий яамд, аймаг, нийслэл, дүүргийн дотоод аудитын албаны албан бичгийг шалгагдсан байгууллагад өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай гэж үзвэл шалгалтын дүнгээр даргын тушаал гаргаж болно. Түүнчлэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, холбогдох арга хэмжээ авахуулахаар эрх бүхий удирдах байгууллага, албан тушаалтанд хандаж болно.

14. Улсын байцаагч санхүүгийн баримтын шалгалтаар гэмт хэргийн шинжтэй зөрчил илрүүлсэн тохиолдолд акт материалыг Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн З-ын 3 дах заалтын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.

15. Шалгалтын явцад төрийн хууль тогтоомжийг зөрчсөн, улсад эд хөрөнгийн хохирол учруулсан нь тогтоогдвол гэм буруутай албан тушаалтанд захиргааны шийтгэл ногдуулж шийтгэвэр бичиж торгууль хүлээлгэнэ.

16. Шийтгэвэрт зөрчил гаргасан хүний аймаг, хот, сум, хороо, овог нэр, гаргасан зөрчлийн товч утга, шийтгэвэр ногдуулсан байгууллагын нэр, хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн холбогдох заалт торгуулийн хэмжээг заана.

17. Шийтгэврийн нэг хувийг зөрчил гаргасан албан тушаалтанд өгнө. Зөрчил гаргасан албан тушаалтан захиргааны шийтгэл ногдуулсаныг эс зөвшөөрвөл шийтгэврийг хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор яамд, аймаг, нийслэл, дүүргийн дотоод аудитын албанд гомдол гаргаж болно. Гомдлыг хүлээн авсан байгууллага уг гомдлыг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдол гаргагч шүүхэд хандах эрхтэй.

18. Захиргааны шийтгэл ногдуулсан тохиолдолд захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулж, тухайн материалыг 30 хоногийн дотор зохих шатны прокурорын газарт хүргүүлж хянуулна.

19. Хуульд өөрөөр заагаагүй бол шалгалтын дүнгийн талаар холбогдох байгууллагаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэнэ.

20. Шалгалтын дүнтэй холбогдож, тухайн байгууллагад явуулсан албан бичиг, шалгалтын тэмдэглэлд дурьдагдсан асуудлын хэрэгжилт болон албан шаардлага, нэг бүрчилсэн актаар

тотоогдсон төлбөр зөрчлийн барагдуулалтыг шалгалт хийсэн улсын байцаагч хяналт тавьж хэрэгжүүлнэ.

21. Шалгалтын дүнг хурлаар хэлэлцсэний дараах З хоногийн дотор шалгуулсан байгууллагын үйл ажиллагааны үнэлэлт, дүгнэлт, цашид авах арга хэмжээг заасан албан бичгийг явуулж, 7 хоногийн дотор төлбөр зөрчлийн шалтгаан, хэрхэн шийдвэрлэхийг тогтоосон хүснэгтийн дагуу компьютерт бичүүлж 10 хоногийн дотор шалгалтын материалыг архивт хүлээлгэж өгнө.

### 3.5 ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АЖИЛЛАХ

ШАЛГАЛТЫН ҮР ДҮНД ИЛЭРСЭН ДУТАГДЛЫГ АРИЛГАХ БОЛОН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТАЛААР УЛСЫН БАЙЦААГЧ АНХААРЧ АЖИЛЛАХ ЁСТОЙ.

01. Шалгалтын мөрөөр ажиллах үйл ажиллагаа гэдэг нь шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээ нь цаг үеэ олсон, үр ашигтай байдлаар шийдэгдсэн эсэхийг тодорхойлох процесс юм.
02. Улсын байцаагч нар өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг хугацаанд нь зөв зүйтэй биелүүлсэн эсэх, шаардлагатай арга хэмжээ авсан эсэхийг тогтооно.
03. Шалгалтын мөрөөр ажиллах үүрэг хариуцлагыг санхүүгийн хяналт шалгалтын байгууллагын журамд заасан байна.
04. Хяналт шалгалтын байгууллагын удирдлага шалгалтын мөрөөр авах арга хэмжээг хариуцана.
05. Шалгалтын мөрөөр ажиллах хугацаа, үүрэг зэргийг хяналт шалгалтын байгууллагын дарга шийдвэрлэнэ.
06. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээг тодорхойлох хүчин зүйлд дор дурдсан хүчин зүйл орно. Үүнд:
  - илэрсэн төлбөр зөрчлийн байдал
  - тайландаа дурдагдсан зөрчлийг арилгахад гарах хүчин чармайлт, өртөг зардал
  - засаж запруулж байгаа үйл ажиллагаатай уялдан гарах эрсдэлийн түвшин
  - засаж запруулах үйл ажиллагааны нарийвчлал /комплекс/
  - цаг хугацааны хамаарал
07. Зарим зөрчил дутагдлын уршиг их бөгөөд яаралтай арга хэмжээ авч засаж запруулах шаардлагатай тохиолдолд улсын байцаагч нар уг арга хэмжээг авхуулах талаар шаардаж, зааж зөвлөх ёстай.
08. Хяналт шалгалтын байгууллагын дарга шалгалтын мөрөөр ажиллах төлөвлөгөөг ажлын төлөвлөгөөндөө багтаан оруулсан байна.

09.Хяналт шалгалтын байгууллагын дарга шалгалтын мөрөөр ажиллахдаа анхаарах зүйл:

-шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хугацаа

-авагдсан арга хэмжээг судалж, үнэлж дүгнэх

-шаардлагатай тохиолдолд авсан арга хэмжээг

баталгаажуулах

-хэрэв шаардлагатай бол дахин шалгалт оруулах

-албан шаардлага бичих

#### 4. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЧАНАРЫН СТАНДАРТ

1. Шалгуулж байгаа байгууллага болон харилцагч байгууллага нь бидний үйлчилгээнээс нилээд чухал асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар санал зөвлөгөөг хүлээж байдаг бөгөөд энэ хүлээлт нь дараах зүйлийг агуулж байдаг. Үүнд:

-үр дүнтэй, ашигтай харилцаа холбоо

-хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцогч багийн тасралтгүй, үр ашигтай хамтын ажиллагаа

-удирдлагын үйл ажиллагаанд үр ашигтай санал зөвлөмж өгөх

-цаг хугацааны тухайн үеийн болон үр дүнтэй үйлчилгээг тус тус хүлээж байдаг

2. Хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байгаа багийн зүгээс өөрийн харилцагч болон шалгуулагч байгууллагын хүсэн хүлээж байгаа тэр хүлээлтүүдийг судлан тэдгээрийг хэрхэн гүйцэтгэх талаар төлөвлөгөө гарган ажиллах хэрэгтэй. Мөн улсын байцаагчдын зүгээс хяналт шалгалтын ажлын явцдаа шалгуулагч байгууллагын зүгээс хүлээж байгаа дээрх хүлээлтүүдийг биелүүлэхийн төлөө чармайн ажиллах нь хяналт шалгалтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэхийн үндэс болно.

##### 4.1 ХАРИЛЦАГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ

Хяналт шалгалтын үйл ажиллагааны чанар үл нөлөөг дээшлүүлэх, шалгуулагч байгууллага, харилцагч нарт үзүүлэх үйлчилгээг чанартай, улам бүр хүртээмжтэй болгоход дараах 8 стандарт шаардлага чухал ач холбогдолтой юм. Үүнд:

01.Хяналт шалгалтын эцсийн үр дүнгээс шалгуулагч байгууллага ямар зүйлийг хүлээж байгааг тодорхойлон гаргах

02.Шалгуулагч байгууллагад хэрэгцээ шаардлагатай байгаа зүйлүүд болон мэргэжил арга зүйн чухал зөвлөмж үйлчилгээнүүдийг судлан тогтоож, тэдгээрт мэргэжлийн дагуу дүн шинжилгээ хийх

03. Хяналт шалгалтын ажлын мэргэжлийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэхийн тулд шалгуулагч байгууллага, харилцагч үйлчлүүлэгч наарт үзүүлэх үйлчилгээний зорилго, зорилтуудыг хөгжүүлэн нэмэгдүүлэх, тэдгээр байгууллагуудаас хүлээж байгаа хүлээлтүүдийг боломжийн түвшинд биелүүлэх. Шалгуулагч байгууллага, харилцагч нараас хүлээж байгаа зүйлсийн талаарх асуудлыг тэдгээрт үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөнд тусган боловсруулсан байх шаардлагатай бөгөөд түүнийг дахин авч үзэж засаж боловсруулах хэрэгтэй.
04. Хяналт шалгалтын ажлын явцад харилцагч байгууллагын дотоод болон гадаад орчны бүхий л хүмүүстэй идэвхтэй хамтын ажиллагаатай байх нь өөрийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар үр нөлөөг дээшлүүлэхэд чухал алхам болно.
05. Шалгуулагч байгууллагын бизнесийн болон бусад үйл ажиллагааны талаар тухай байгууллагын удирдлагтай ярилцаж, тэдний үйл ажиллагаанд ухаалаг, мэргэжлийн дагуу маш сайн зөвлөгөө өгч байх ёстой.
06. Шалгуулагч байгууллага болон харилцагч нарын зах зээлд эзлэх байр суурь болон тэдний цаашдын хөгжлийн чиг хандлагыг зөв зүйтэй тодорхойлоход өөрийн зүгээс энэ талаарх санал бодлоо танилцуулах нь тэдэнд үзүүлэх үйлчилгээг улам бүр чанартай болгохын дээр цаашдын тасралтгүй хамтын ажиллагааг өргөжүүлэх таатай боломж болдог.
07. Мэргэжил, арга зүйн талаар өгч байгаа зөвлөгөө нь хууль эрх зүйн болон бусад бүх талын баталгааг хангаж байхын зэрэгцээгээр улсын байцаагчдаас шалгуулагч байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээг цаг алдалгүй шуурхай байлгах нь харилцагч талуудын хоорондын харилцан бие биенээ хүндэтгэн авч үзэх харилцааны үндэс болно.
08. Харилцагч байгууллага болон шалгуулагч байгууллагын зүгээс хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын ажлыг үнэлэх үнэлэмж нь тэдэнд үзүүлсэн үйлчилгээний чанар, үр ашиг, цаг хугацаатай хэрхэн уялдаа холбоотой байсан зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалж байдаг.

Хяналт шалгалтын ажлын явцад харилцагч байгууллага болон шалгуулагч байгууллагад үзүүлэх үйлчилгээний талаар баримтлах ерөнхий бодлого чиглэлийг батлан гаргахад энэхүү “Харилцагчид үзүүлэх үйлчилгээний стандарт” нь ач холбогдолтой юм. Чухамхүү эдгээр үйлчилгээ, хийх ажил, зөвлөгөөг бизнесийн болон төрийн байгууллагын аль салбарт хэрхэн хэрэгжүүлэх талаар хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байгаа нийт улсын байцаагч нар анхааран ажиллах шаардлагатай.

## **5. ХАРААТ БУС БАЙДАЛ**

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИД ШАЛГАЛТ ХИЙЖ БУЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ХАРААТ БУС БАЙНА.**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч хяналт шалгалтыг явуулахдаа чөлөөтэй бөгөөд бодит байдлыг тусгаж харуулах нөхцөлтэй байгаа бол хараат бус байна гэж үзнэ. Хараат бус байдал нь улсын байцаагч шалгалтыг зөв шудрага явуулсан үндэслэлгүй болон хөндлөнгийн дүгнэлт гаргахаас хамгаалах ач холбогдолтой байдаг. Хараат бус байдал нь хяналт шалгалтын байгууллагын зохион байгуулалт, эрх зүйн байдал болон байцаагчийн бодит байдлыг тусгах, зорилгодоо хүрэх арга барилаар илэрхийлэгдэнэ.

**5.1 Хяналт шалгалтын байгууллагын зохион байгуулалтын хараат бус байдал**

Санхүүгийн хяналт шалгалт явуулж байгаа газрын зохион байгуулалт, эрх зүйн байдал хяналт шалгалт явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

01. Улсын байцаагч нь өөрийн удирдлага болон зөвлөлөөс дэмжлэг авах, бусад байцаагч нартай санал солилцох журмаар шалгалтыг хөндлөнгийн оролцоогүйгээр чөлөөтэй явуулах ёстой.
02. Хяналт шалгалтын байгууллагын дарга нь байцаагчийн бие даан хараат бус ажиллах тал дээр дэмжлэг үзүүлэх хариуцлагыг хүлээнэ.
03. Хяналт шалгалтын байгууллагын үүрэг, зорилго, хариуцлагыг албан ёсоор баталж хуульчилсан байна.
04. Хяналт шалгалтын байгууллагын удирдлага нь шалгагдаж байгаа байгууллагын үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчинг шалгалтын тэмдэглэл, нэг бүрчилсэн акт, танилцуулга материалтай шалгалтын эцсийн дүгнэлт гарахаас өмнө танилцаж мэдсэний үндсэн дээр тухайн байгууллагын үйл ажиллагаанд өгч байгаа үнэлэлт дүгнэлт хэр оновчтой бодитой байгааг хянаж байх үүрэгтэй.
05. Хяналт шалгалтын байгууллагын удирдлага нь шалгагдаж байгаа байгууллага, үйлчлүүлэгчийн удирдлага болон даргын зөвлөлтэй уулзаж улсын байцаагч хэрхэн хараат бус, бие даасан байдлаар ажилласан талаар нь зөвлөлдөх эрхтэй.

**5.2 Хяналт шалгалтын байцаагч шалгалтыг хэрхэн үнэн зөв, бодит байдлыг тусгаж харуулсанын хараат бус байдал тодорхойлогдоно.**

01. Байгууллагын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг улсын байцаагч нар сэтгэл зүй, оюун санааны хувьд хараат бус бие даасан байх хэрэгтэй.

02. Хяналт шалгалтын байцаагч шалгалтын асуудлаарх өөрийн дүгнэлтийг бусдын шахалтанд автахгүйгээр гаргана.

03. Байцаагч нар мэргэжлийн дагуу шалгалтын бодит байдлыг харуулахад саад нөлөө үзүүлэх ямар нэг байдалд ороогүй байх ёстой. Үүнд:

- Хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх явцад зарим нэг тохиолдолд улсын байцаагч нар хяналт шалгалт хийж гүйцэтгэсний төлөө шан харамж авахыг хориглох ба хэрэв авсан тохиолдолд тухайн хяналт шалгалтын ажлын дүгнэлт, олж тогтоосон зүйлүүдийн бие даасан хараат бус байдал алдагдаж шалгалтын зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болно. Дээрхи санаа нь хяналт шалгалтын ажлаас гадна ямар нэг төлбөртэй үйлчилгээг үзүүлж байгаа тохиолдолд авч үзэх асуудал юм.

- Хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхэд шалгуулж буй этгээдтэй ямар нэг байдлаар гэр булийн болон хувийн бизнесийн харилцаатай байх тохиолдолд хийж байгаа ажлын үнэн зөв, бодитой байх чанар алдагддаг. Учир нь аливаа үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлтийг өөрчлөх, алдаа мадгийг нуун дарагдуулах зэрэг үйлдэлд шалгалтыг хийж байгаа улсын байцаагчид түүний гэр бүл болон танил нөхдөөс нөлөөлөх магадлал гардагтай холбоотой юм.

- Хяналт шалгалтын ажлын явцад шалгууллагч байгууллага болон үйлчлүүлэгч нараас мөнгө зээлэх, хөнгөлөлттэй бараа, үйлчилгээг авахаас байнга татгалзах хэрэгтэй.

- Хувьцаа болон бусад хэлбэрээр ашиг авах нь шалгалтын бие даасан байдалд нөлөөлнө.

## 6. ЁС ЗҮЙН СТАНДАРТ

- 6.1 Хяналт шалгалтын байцаагч нь хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэхдээ бусдыг хүндэтгэн харилцах бөгөөд өөрийн хүлээсэн үүрэг, зорилтоо бүрэн биелүүлж ажиллана.
- 6.2 Хяналт шалгалтын байцаагч нь шалгууллагч байгууллагын үйл ажиллагааг үнэн зөвөөр шалган дүгнэлт гаргахын зэрэгцээгээр тухайн байгууллагад үйлчилгээ үзүүлж байгаа гэдэг асуудлыг орхигдуулж болохгүй юм. Гэхдээ хяналт шалгалтын байцаагч нь шалгалтын явцад ямар нэгэн хууль тогтоомж зөрчих болон зохимжгүй үйлдэл хийхийг хориглоно.
- 6.3 Хяналт шалгалтын улсын байцаагч нь дотоод хяналт шалгалтын болон өөрийн байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байхын

зэрэгцээгээр байгууллагын үйл ажиллагааны талаарх санал бодлоо байнга илэрхийлж байх хэрэгтэй.

- 6.4 Хяналт шалгалтын байцаагч нь тухайн шалгуулж байгаа байгууллагатай ямар нэг ашиг сонирхлын хоорондын зөрчилдөөн байгаа тохиолдолд өөрийн үүрэг хариуцлага, зорилгоо ханганд ажиллахаас гадна тухайн хяналт шалгалтын ажлыг зогоох буюу хийхгүй байх хэрэгтэй.
- 6.5 Хяналт шалгалтын ажилтан хууль эрхийг зөрчиж шалгуулагч байгууллагын ажилтнууд, харилцагч байгууллагууд, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч нараас мөнгөн хандив тусlamж болон бусад бараа ажил, үйлчилгээг авахгүй байх.
- 6.6 Хяналт шалгалтын байцаагч нь дээрх үйлчилгээг зөвхөн өөрийн ажил үүргээ биелүүлэхтэй холбогдон гарах арга хэмжээнд албан ёсоор авч болох боловч эдгээр нь ямар нэгэн хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн байх ёсгүй юм.
- 6.7 Хяналт шалгалтын ажилтан нь аливаа байгууллагад хийж байгаа ажлыг мэргэжлийн арга зүйн стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэх шаардлагатай.
- 6.8 Хяналт шалгалтын байцаагч нь өөрийн хүлээх хариуцлагын үндсэн хэсэг болох мэдээллийн үнэн бодитой байдлыг ханганд ажиллахын тулд аливаа ашиглаж байгаа мэдээллийн үнэн бодитой эсэхийг нягтлан анхааралтай авч үзэх хэрэгтэй. Мөн ямар нэгэн худал мэдээллийг хувь хүний ашиг сонирхлын үүднээс ашиглахыг хориглох ба хяналт шалгалтын ажлын эцсийн дүгнэлт гараагүй байхад хууль дүрэм зөрчин тухайн байгууллагын хүмүүст хүргэхийг хориглоно.
- 6.9 Хяналт шалгалтын байцаагч нь өөрийн хийж гүйцэтгэсэн ажил, шалгалтын тэмдэглэл, нэг бүрчилсэн акт, танилцуулгыг бэлтгэх явцдаа шалгалтын явцад олж тогтоосон үнэн бодитой мэдээллийг байгаа байдлаар нь илтгэх шаардлагатай бөгөөд хууль тогтоомж зөрчин тэдгээрийг өөрчлөх эрх байхгүй.
- 6.10 Хяналт шалгалтын байцаагч нь шалгууллагч байгууллагын цаашдын үйл ажиллагааны төлөвлөлт, зорилтыг боловсронгуй болгоход туслах үүднээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүн шинжилгээг бодитой, үр дүнтэй гаргахын зэрэгцээгээр өөрийн ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэхийн төлөө анхааран ажиллаж шалгууллагч байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах хэрэгтэй.
- 6.11 Хяналт шалгалтын байцаагч нь өөрийн мэргэжлийн арвин их дадлага туршлагатай байхын дээр хяналт шалгалтын арга зүйг боловсронгуй болгох асуудлаар байнга шинийг санаачлагч байх хэрэгтэй. Мөн

бусад хүмүүстэй харилцах ёс суртахууны өндөр хэм хэмжээг баримтлан ажиллахын зэрэгцээгээр харилцааны сэтгэл зүйг сайтар судалсан байх шаардлагатай юм. Хяналт шалгалтын байгууллагаас нийт ажиллагсдын дунд мэргэжлийн болон харилцааны асуудлаар жил бүр түвшин тогтоо шалгалтыг авч байх нь хүний нөөцийн зөв бодлого хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой асуудал болно.

---оо---